



**НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Аудитын код: САГ-2018/129/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Д.Цэгмиддорж
Утас: 261740 Цахим хаяг: tsegmiddorjd@audit.gov.mn

Амгалан Ахуй Аудит ХХК-ийн захирал Д.Амгалан
Утас: 77011044 Цахим хаяг: amgalanahui.audit@gmail.com

Чанарын хяналтын мэргэжилтэн Д.Дэлгэрэхжаргал
Утас: 77011044 Цахим хаяг: degi1028@yahoo.com

Аудитор Б.Буянтэгш
Утас: 77011044 Цахим хаяг: Buyan.audit@gmail.com



Улаанбаатар хот

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	2
2.5	Дотоод хяналт	3
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	4
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.9.1	Татварын болон нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын талаар	4
2.9.2	Үндсэн хөрөнгийн талаар	4
2.9.3	Дансны авлагын талаар	4
2.9.4	Орлого, зарлагын талаар	5
2.9.5	Төсвийн орлогын бүрдүүлэлтийн талаар	5
2.9.6	Санхүүгийн тайлангийн талаар	5
2.9.7	Анхан шатны баримтын талаар	6
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	6
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	6
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	6
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	6
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	7
3	Менежментийн захидал	8
3.1	Анхан шатны баримтын талаар	9
3.2	Төсвийн орлогын бүрдүүлэлтийн талаар	9
3.2	Санхүүгийн тайлангийн талаар	10
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	11
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлынтайлан	11
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.5	Аудит хийгдсэн батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлан	17
4.6	Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилт төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.7	Аудит хийгдсэн нэгтгэл санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19



НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ
Ё.ЭНХБАЯР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Насан туршийн боловсролын үндэсний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Насан туршийн боловсролын үндэсний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар Насан туршийн боловсролын үндэсний төвийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн



гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2 Аудитын тайлан

2.1 Оршил

Насан туршийн боловсролын үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Насан туршийн боловсролын үндэсний төвийн захирал Ё.Энхбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд анхан шатны баримтууд “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7”, үндсэн үйл ажиллагаанаас олох орлогын төсөв “Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 заалт”-ыг хэрэгжүүлж ажиллах аргачлал болон санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Насан туршийн боловсролын үндэсний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Насан туршийн боловсролын үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 05-наас 2018 оны 2 дугаар сарын 23-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 23-нд эцэслэн

баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн. “Амгалан Ахуй Аудит” ХХК-ийн аудитор Б.Цэцэгмаа, аудитор Б.Буянтэгш туслах аудитор Ж.Отгонбаяр нар гүйцэтгэж, аудитын чанарын хяналтыг аудитын менежер Д.Дэлгэрэхжаргал чанарыг хэрэгжүүлж, захирал Д.Амгалан хянан удирдав.

Насан туршийн боловсролын үндэсний төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний Аудитын газрын 2018 оны 2 дугаар сарын 02-ныөдрийн 03/318 дугаар албан бичгээр Амгалан Ахуй Аудит ХХК-д ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Насан туршийн боловсролын үндэсний төв нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4, Боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь заалтыг үндэслэн Насан туршийн боловсролын үндэсний төвийн бүтэц орон тоог баталсан байна.

Насан туршийн боловсролын үндэсний төвийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Насан туршийн боловсролын үндэсний төв нь зайны сургалтын бодлого шийдвэрийг боловсруулахад төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангах, бодлогын хэрэгжилтийг үндэсний түвшинд зохион байгуулж мэргэжил арга зүйн удирдлагаар хангадаг.

Насан туршийн боловсролын үндэсний төвийн эрхэм зорилго нь

Иргэн бүр нийгмийн хөгжлийн чиг хандлага, хувь хүний эрх ашигт нийцсэн боловсролыг насан туршдаа тасралтгүй эзэмшиж, амьдралынхаа чанараа дээшлүүлэхэд шаардагдах боловсролын агуулга, арга зүй, үнэлгээ, орчин, боловсон хүчин, санхүүг бүрдүүлэхэд оршино.

Үйл ажиллагааны стратегийн зорилт

Насан туршийн боловсролын үндэсний төв нь насан туршийн боловсрол, бичиг үсгийн болон гэр бүлийн боловсрол, иргэний боловсрол, урлаг гоо зүйн боловсрол, амьдрах ухааны боловсрол зэргийг хамарсан өргөн агуулгатай байх бөгөөд бодлогын хүрээнд уг тогтолцоог насан туршийн боловсролын тогтолцоо болгон өргөжүүлэн хөгжүүлж байна.

Насан туршийн боловсролын үндэсний төвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн

тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Насан туршийн боловсролын үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, 5 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 18 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Насан туршийн боловсролын үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Насан туршийн боловсролын үндэсний төв нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “асолус” програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт


Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Насан туршийн боловсролын үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалттай гэж үзлээ.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн шууд захирагчид 2017 онд нийт 191,420.4 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна. Үүнээс урсгал үйл ажиллагааны санхүүжилтээс 137,613.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагаанаас төвлөрүүлэх нь 47,600.0 мянган төгрөг батлагдсанаас 310.1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэн 47,289.9 мянган төгрөгөөр тасалдуулсан байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан. Үүнд үндсэн цалин 17,527.7 мянган төгрөг, нэмэгдэл цалин 7,729.4 мянган төгрөг, ашаахуун 1,011.6 мянган төгрөг, шуудан холбоо, интернэтийн төлбөр 1,948.0 мянган төгрөг тус тус зарцуулаагүй байна.



2.7 Шилэн дансны мэдээлэл

Насан туршийн боловсролын үндэсний төв нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу тогтоосон хуулийн хугацаанд жил, улирал, сар, тухай бүр мэдээллийг оруулсан байна. Байгууллагын цахим хуудас www.shilendans.gov.mn/org/1112 сайтад

шилэн дансны цэсийг холбосон. Шилэн дансны мэдээлэлтэй танилцахад нийт 16 мэдээлэл оруулахаас цаг тухай бүрт нь 14 мэдээ оруулсан ба 2 мэдээг байршуулаагүй байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 18 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Татварын болон нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын талаар

2017 оны 12 дугаар сарын 31-ний Хувь хүний орлогын албан татварын тайлангаар 977.5 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангаар 109.2 мянган төгрөгийн авлага тус тус байна. Дээрх татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн санхүүгийн тайлангийн авлага дансанд бүртгэх нийт зөрүү 1,086.7 мянган төгрөг байна.

Энэ нь эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байгаа бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дахь заалтаар “үнэн зөв байх” зарчим тодорхойлсныг зөрчсөн байна. Мөн ХХОАТ-ын тухай хуулийн 4.1.4 “суутгагч” гэж албан татвар төлөгчийн орлогод энэ хуулийн дагуу албан татвар ногдуулан суутгаж, Улсын болон орон нутгийн төсөвт шилжүүлэх үүрэг бүхий этгээдийг”, мөн хуулийн 26 дугаар зүйлд “Албан татвар ногдуулах, төсөвт төлөх” гэсэн заалт бүрийг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх ба үнэн зөв тайлагнах.

Шийдвэрлэсэн нь: Журналын бичилт хийж Холбогдох авлага данснуудын дт, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж кт гэсэн залруулах бичилт хийж залруулсан.

2.9.2 Үндсэн хөрөнгийн талаар


Үндсэн хөрөнгийн элэгдлийг 816.7 мянган төгрөгөөр илүү тооцож бүртгэсэн байна.

Энэ нь тохиолдсон байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй ба Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх заалт “үнэн зөв байх” гэсэн зарчмыг баримтлах.

Шийдвэрлэсэн нь: Журналын бичилт Нөхөн тооцсон элэгдлийн зардлын дүнгээр Өмнөх үеийн үр дүн дт, Элэгдлийн зардал кт гэсэн залруулга хийсэн.

2.9.3 Дансны авлагын талаар

Тогтвортой хөгжлийн боловсрол төслийн татан төвлөрүүлэлтийг 2016 онд 754.6 мянган төгрөг, 2017 онд 3,669.2 мянган төгрөг нийт 4,423.8 мянган төгрөгийг зардлаар бүртгэсэн байна. Тухайн ажил гүйлгээ нь, зардлын шинж чанарыг агуулаагүй ба 2016 он болон 2017 оны зарцуулаагүй үлдсэн нэмэлт санхүүжилтийн орлого юм.



Энэ нь эрх ба үүрэг, хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: УСНББОУС1-ийн 1, 2-ыг баримтлан залруулга хийсэн.

Журналын бичилт 754.6 мянган төгрөгийг Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс (131101) дт, Өмнөх үеийн үр дүн (51210) кт

Журналын бичилт: 3,669.2 мянган төгрөгийг Байгууллагаас авах авлага (33510) дт, Засгийн газрын дотоод шилжүүлэг (213101) кт гэсэн залруулах бичилт хийж залруулсан.

2.9.4 Орлого, зарлагын талаар

Насан туршийн боловсролын үндэсний төв нь 2017 оны 4 дүгээр сарын 26-нд 6,170.4 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогоор 3 ширхэг /DELL/ компьютер худалдан авсан ба уг хөрөнгийг тухайн өдөр шууд зардалд бүртгэсэн байна. Дээрх бүртгэгдсэн хөрөнгийг 2017 оны 07 дугаар сарын 01-нд үндсэн хөрөнгөд дахин үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэсэн нь орлого, зарлагыг өсгөж илэрхийлэхэд нөлөөлсөн байна.

Энэ нь үнэн зөв байдал, хэмжилт, тасалбар болголт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй ба “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 6.1 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэж заасныг зөрчсөн ба Монгол Улсын Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.33-ийн <в>-д, Монгол Улсын Сангийн сайдын 2013 он 269 дүгээр тушаалын 1-д заасан аргачлалаар Нягтлан бодох бүртгэлээ хөтлөөгүй байна.


Шийдвэрлэсэн нь: Журналын бичилт Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж дт, Багаж, техник хэрэгслийн зардал кт гэсэн залруулах бичилт хийж залруулсан.

2.9.5 Төсвийн орлогын бүрдүүлэлтийн талаар

Насан туршийн боловсролын үндэсний төв нь Сангийн сайдын 2016 оны 438 тоот “Төсвийн хуваарь батлах тухай” тушаал батлагдсаны дагуу 2017 онд 47,600.0 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагаанаас төвлөрүүлэх төсвөөс 310.0 мянган төгрөгийг улсын төсөвт оруулсан байна. Улсын төсвийн орлогын төлөвлөгөөг 47,289.9 мянган төгрөгөөр тасалсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1”хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалтыг мөрдөж, төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах зөвлөмж хүргүүлсэн



2.9.6 Санхүүгийн тайлангийн талаар

Насан туршийн боловсрол үндэсний төв нь санхүүгийн тайлангаа 2018 оны 01 дүгээр сарын 26-нд аудитын байгууллагад хүргүүлсэн ба 1 хоногоор хоцроосон нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 “төсвийн шууд захирагч жилийн төсвийн

гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлэх...” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлсэн.

Анхан шатны баримтын талаар

Байгууллагын үйл ажиллагаанд зориулж худалдан авалт хийсэн бараа материалын 200.0 мянган төгрөгийн е-баримтыг тухайн байгууллагын нэр дээр аваагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” дэх заалтыг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 Татварын ерөнхий хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлсэн.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Сангийн сайдын 2016 оны 438 тоот “Төсвийн хуваарь батлах тухай” тушаал батлагдсаны дагуу Насан туршийн боловсролын үндэсний төв нь 2017 онд 47,600.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх байсан хэдий ч 310.0 мянган төгрөгийн орлого олсон байна. Энэ нь телестуди болон хэвлэх цехийн тоног төхөөрөмж хуучирсан буюу зах зээлд өрсөлдөх чадваргүй болсон байдлыг харгалзаж өөрийн үйл ажиллагаанаас олох орлогыг бодитоор төсөвлөж, төсөв гүйцэтгэлийн санхүүгийн тайланг үнэн зөв гаргах.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Насан туршийн боловсролын үндэсний төвийн дараагийн аудитаар тусгайлан шалгах асуудал байхгүй.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Насан туршийн боловсролын үндэсний төвийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаас 59,987.5 мянган төгрөгийн 9 алдаа зөрчлийг илрүүлсэн. Үүнээс 59,787.5 мянган төгрөгийн 5 залруулга, 200.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн. Цаашид дээрх зөрчлийг давтахгүй байхыг анхаарч ажиллахыг зөвлөж байна.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Насан туршийн боловсролын үндэсний төвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд түүврээр аудит хийсэн нь аудитаар залруулахаар тохиролцсон алдаа, зөрчил дутагдал гараагүй ба зөвлөмж өгөөгүй байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛАН ДҮГНЭЛТ


Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгов.

Насан туршийн боловсролын үндэсний төвийн 2017 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнгээс тооцсон. Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 1 хувиар буюу 1,063.8 мянган төгрөгөөр тооцох нь зүйтэй гэж үзлээ.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Насан туршийн боловсролын үндэсний төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Бид Насан туршийн боловсролын үндэсний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Насан туршийн боловсролын үндэсний төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Анхан шатны баримтын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Байгууллагын үйл ажиллагаанд зориулж худалдан авалт хийсэн бараа материалын 200.0 мянган төгрөгийн е-баримтыг тухайн байгууллагын нэр дээр аваагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

“Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.7, “Татварын ерөнхий хууль”-ийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлсэн.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 4 дүгээр сарын 05-ны дотор ирүүлэх;

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлагнал буруу илэрхийлэгдэнэ

Хуулийг зөрчиж хуулийн хариуцлага хүлээх

Ашиглан ба залилангийн эрсдэлүүд үүсэх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

3.2 Төсвийн орлогын бүрдүүлэлтийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

2017 онд Улсын төсвийн орлогын төлөвлөгөөг 47,289.9 мянган төгрөгөөр тасалсан байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлсэн.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 4 дүгээр сарын 05-ны дотор ирүүлэх;

01 ЗӨРЧИЛГҮЙН САНАЛ ДУГНЭЛТ
Төсвийн захирагчийн хариу

Эрсдэлүүд

Улсын төсвийн орлогын төлөвлөгөө тасрах батлагдсан зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах.

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

3.3 Санхүүгийн тайлангийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Насан туршийн боловсрол үндэсний төв нь санхүүгийн тайлангаа 2018 оны 1 дүгээр сарын 26-нд аудитын байгууллагад хүргүүлсэн ба 1 хоногоор хоцроосон нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 “төсвийн шууд захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлэх...” гэсэн заалтыг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 “төсвийн шууд захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлэх...” заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлсэн.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 4 дүгээр сарын 05-ны дотор ирүүлэх;

Эрсдэлүүд

Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцуулах

Нэгтгэсэн тайланд нөлөөлөх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.




4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫНТАЙЛАН

НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	/төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,577,778.00	8,333,594.79
33	АВЛАГА	-	4,755,816.79
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага		3,669,152.00
335	Бусад авлага		977,481.66
3351	Байгууллага		109,183.13
35	БАРАА МАТЕРИАЛ	3,577,778.00	3,577,778.00
354	Хангамжийн материал	3,577,778.00	3,577,778.00
35410	Бичиг хэргийн материал	131,000.00	131,000.00
35420	Аж ахуйн материал	586,370.00	586,370.00
35470	Бусад хангамжийн материал	2,860,408.00	2,860,408.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	126,126,474.22	102,800,755.64
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	126,126,474.22	102,800,755.64
392	Биет хөрөнгө	125,796,474.30	102,580,755.76
39205	Машин, тоног төхөөрөмж	193,246,881.30	199,417,281.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(79,389,001.26)	(107,277,542.84)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,562,514.00	16,562,514.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,694,919.74)	(6,192,496.70)
39217	Номын фонд	71,000.00	71,000.00
393	Биет бус хөрөнгө	329,999.92	219,999.88
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хасагдуулга	(220,000.08)	(330,000.12)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	129,704,252.22	111,134,350.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	129,704,252.22	111,134,350.43
51	Засгийн газрын хувь оролцоо	129,704,252.22	111,134,350.43
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	151,585,259.48	151,585,259.48
51101	Өмч: -Төрийн өмч	151,585,259.48	151,585,259.48
512	Хуримтлагдсан үр дүн	(21,881,007.26)	(40,450,909.05)
51210	Өмнөх үеийн үр дүн	(21,881,007.26)	(21,943,130.26)
51220	Тайлант үеийн үр дүн		(18,507,778.79)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	129,704,252.22	111,134,350.43



**4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	619,978,008.44	288,504,533.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,372,860.00	6,480,460.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,000,000.00	6,480,460.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,000,000.00	6,480,460.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	310,060.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	6,170,400.00
121	Хөрөнгийн орлого	10,372,860.00	-
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	10,372,860.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	608,605,148.44	282,024,073.35
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	141,591,600.00	137,433,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	141,591,600.00	137,433,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	467,013,548.44	144,590,673.35
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	422,025,812.44	144,590,673.35
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	36,107,736.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,880,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	634,950,982.88	307,012,312.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	634,195,745.88	302,982,060.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	634,195,745.88	302,982,060.79
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	310,568,549.44	113,999,822.00
210101	Цалин	310,568,549.44	113,999,822.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,072,484.00	12,498,267.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	25,539,529.00	7,953,443.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	906,589.00	1,083,298.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,133,238.00	961,874.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	226,652.00	227,241.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,266,476.00	2,272,411.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,200,000.00	4,200,000.00
210304	Байрны түрээс	4,200,000.00	4,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,497,851.00	5,468,691.00
210401	Бичиг хэргийн материал	1,186,376.00	1,392,175.00
210402	Тээвэр, шатахууны зардал	4,180,000.00	2,746,350.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	2,316,275.00	996,666.00
210404	Ном, хэвлэлийн зардал	-	101,000.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	400,400.00	232,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-
210601	Багаж хэрэгсэл	-	-
2107	Томилот, зочны зардал	51,127,000.00	16,716,600.00
210702	Дотоод томилотын зардал	51,127,000.00	16,716,600.00

Насан туршийн боловсролын үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	401,500.00	67,293,516.21
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	66,933,016.21
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	401,500.00	360,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	233,328,361.44	82,805,164.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	344,200.00	1,567,900.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	204,240,839.00	51,741,146.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,743,322.44	29,496,118.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	755,237.00	4,030,251.35
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	755,237.00	130,251.35
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	755,237.00	130,251.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	3,900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	3,900,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(14,972,974.44)	(18,507,778.79)
7	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(14,972,974.44)	(18,507,778.79)



4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

АСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	151,585,259.48		(6,908,032.82)	144,677,266.66
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	151,585,259.48		(6,908,032.82)	144,677,266.66
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Тайлант үеийн үр дүн			(14,972,974.44)	(14,972,974.44)
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	151,585,259.48		(21,881,007.26)	129704252.2
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(62,123.00)	(62,123.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			(21,943,130.26)	129,642,129.22
Тайлант үеийн үр дүн			(18,507,778.79)	(18,507,778.79)
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	151,585,259.48		(40,450,909.05)	111,134,350.43



4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	624,680,236.44	298,916,536.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,449,524.00	9,330,060.00
120	Нийтлэг татварын бус орлого	15,449,524.00	9,330,060.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	15,449,524.00	9,330,060.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	310,060.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,449,524.00	9,020,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	609,230,712.44	289,586,476.35
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	141,591,600.00	137,433,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	141,591,600.00	137,433,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	467,013,548.44	151,515,670.35
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	422,025,812.44	151,515,670.35
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	36,107,736.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,880,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	625,564.00	637,406.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	625,564.00	637,406.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	624,682,236.44	298,916,536.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	624,682,236.44	298,916,536.35
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	623,926,999.44	291,217,133.00
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	314,994,138.44	114,637,228.00
210101	Үндсэн цалин	310,875,738.44	95,928,867.00
210102	Нэмэгдэл	-	8,747,161.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,118,400.00	9,961,200.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	30,072,483.00	12,498,267.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	25,481,529.00	7,953,443.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	918,189.00	1,083,298.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,147,740.00	961,874.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	229,547.00	227,241.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,295,478.00	2,272,411.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	4,200,000.00	4,200,000.00
210304	Байрны түрээс	4,200,000.00	4,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,097,315.00	5,468,691.00
210401	Бичиг хэрэг	583,340.00	1,392,175.00
210402	Тээвэр, шатахуун	94,800.00	2,746,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,816,275.00	996,666.00
210404	Ном, хэвлэл	-	101,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	602,900.00	232,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	6,170,400.00
210601	Багаж техник хэрэгсэл	-	6,170,400.00
2107	Томилолт, зочны зардал	51,127,000.00	16,716,600.00

Насан туршийн боловсролын үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210701	Дотоод албан томилолт	51,127,000.00	16,716,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	401,500.00	68,380,181.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	-	68,019,681.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	401,500.00	360,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	219,034,563.00	63,145,766.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,793,724.00	10,587,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	204,240,839.00	52,557,866.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	755,237.00	7,699,403.35
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	755,237.00	3,799,403.35
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	755,237.00	3,799,403.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	3,900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	3,900,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(2,000.00)	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(2,000.00)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-



4.5 Аудит хийгдсэн БАТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	191,420,400.00	137,613,209.00	53,807,191.00	71.89
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	191,420,400.00	137,613,209.00	53,807,191.00	71.89
210	Бараа, үйлчилгээний зардал	181,133,400.00	133,713,209.00	47,420,191.00	73.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	139,256,700.00	113,999,822.00	25,256,878.00	81.86
210101	Үндсэн цалин	112,819,200.00	95,291,461.00	17,527,739.00	84.46
210102	Нэмэгдэл	16,476,600.00	8,747,161.00	7,729,439.00	53.09
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	9,960,900.00	9,961,200.00	(300.00)	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,747,100.00	12,498,267.00	3,248,833.00	79.37
210201	Тэтгэврийн даатгал	10,020,744.00	7,953,443.00	2,067,301.00	79.37
210202	Тэтгэмжийн даатгал	1,431,539.00	1,083,298.00	348,241.00	75.67
210203	ҮОМШӨ ний даатгал	1,145,317.00	961,874.00	183,443.00	83.98
210204	Ажилгүйдлийн даатгал	286,222.00	227,241.00	58,981.00	79.39
210205	Эрүүл мэндийн даатгал	2,863,278.00	2,272,411.00	590,867.00	79.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,258,000.00	4,200,000.00	58,000.00	98.64
210304	Байрны түрээс	4,258,000.00	4,200,000.00	58,000.00	98.64
2104	Хангамж, бараа материалын зардал	6,633,200.00	1,993,891.00	4,639,309.00	30.06
210401	Бичиг хэрэг	619,300.00	590,375.00	28,925.00	95.33
210402	Тээвэр (шатахуун)	1,084,900.00	73,350.00	1,011,550.00	6.76
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	2,944,700.00	996,666.00	1,948,034.00	33.85
210404	Ном, хэвлэл	356,400.00	101,000.00	255,400.00	28.34
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,627,900.00	232,500.00	1,395,400.00	14.28
2107	Томилолт, зочны зардал	1,448,000.00	-	1,448,000.00	-
210702	Дотоод албан томилолт	1,448,000.00	-	1,448,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	766,500.00	582,029.00	184,471.00	75.93
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	222,000.00	221,529.00	471.00	99.79
210806	Мэдээллийн технологийн зардал	544,500.00	360,500.00	184,000.00	66.21
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	13,023,900.00	439,200.00	12,584,700.00	3.37
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,023,900.00	439,200.00	12,584,700.00	3.37
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,287,000.00	3,900,000.00	6,387,000.00	37.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,287,000.00	3,900,000.00	6,387,000.00	37.91
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,387,000.00	-	6,387,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	3,900,000.00	3,900,000.00	-	100.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан
НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	146,278,618.00	(146,278,618.00)	-
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	146,278,618.00	(146,278,618.00)	-
210	Бараа, үйлчилгээний зардал	146,278,618.00	(146,278,618.00)	-
2104	Хангамж, бараа материалын зардал	3,474,800.00	(3,474,800.00)	-
210401	Бичиг хэрэг	801,800.00	(801,800.00)	-
210402	Тээвэр (шатахуун)	2,673,000.00	(2,673,000.00)	-
2106	Эд хогшил худалдан авах	6,170,400.00	(6,170,400.00)	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,170,400.00	(6,170,400.00)	-
2107	Томилолт, зочны зардал	16,716,600.00	(16,716,600.00)	-
210702	Дотоод албан томилолт	16,716,600.00	(16,716,600.00)	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	67,798,152.00	(67,798,152.00)	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,798,152.00	(67,798,152.00)	-
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	52,118,666.00	(52,118,666.00)	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	52,118,666.00	(52,118,666.00)	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	146,278,618.00	(146,278,618.00)	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	146,278,618.00	(146,278,618.00)	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	146,278,618.00	(146,278,618.00)	-



4.7 Аудит хийгдсэн нэгтгэл санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ДҮН	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	191,420,400.00	283,891,827.00	(92,471,427.00)	148.31
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	191,420,400.00	283,891,827.00	(92,471,427.00)	148.31
210	Бараа, үйлчилгээний зардал	181,133,400.00	279,991,827.00	(98,858,427.00)	154.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	139,256,700.00	113,999,822.00	25,256,878.00	81.86
210101	Үндсэн цалин	112,819,200.00	95,291,461.00	17,527,739.00	84.46
210102	Нэмэгдэл	16,476,600.00	8,747,161.00	7,729,439.00	53.09
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	9,960,900.00	9,961,200.00	(300.00)	100.00
210104	Урамшуулал	-	-	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,747,100.00	12,498,267.00	3,248,833.00	79.37
210201	Тэтгэврийн даатгал	10,020,744.00	7,953,443.00	2,067,301.00	79.37
210202	Тэтгэмжийн даатгал	1,431,539.00	1,083,298.00	348,241.00	75.67
210203	ҮОМШӨ ний даатгал	1,145,317.00	961,874.00	183,443.00	83.98
210204	Ажилгүйдлийн даатгал	286,222.00	227,241.00	58,981.00	79.39
210205	Эрүүл мэндийн даатгал	2,863,278.00	2,272,411.00	590,867.00	79.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,258,000.00	4,200,000.00	58,000.00	98.64
210304	Байрны түрээс	4,258,000.00	4,200,000.00	58,000.00	98.64
2104	Хангамж, бараа материалын зардал	6,633,200.00	5,468,691.00	1,164,509.00	82.44
210401	Бичиг хэрэг	619,300.00	1,392,175.00	(772,875.00)	224.80
210402	Тээвэр (шатахуун)	1,084,900.00	2,746,350.00	(1,661,450.00)	253.14
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	2,944,700.00	996,666.00	1,948,034.00	33.85
210404	Ном, хэвлэл	356,400.00	101,000.00	255,400.00	28.34
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,627,900.00	232,500.00	1,395,400.00	14.28
2106	Эд хогшил худалдан авах	-	6,170,400.00	(6,170,400.00)	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	6,170,400.00	(6,170,400.00)	-
2107	Томилолт, зочны зардал	1,448,000.00	16,716,600.00	(15,268,600.00)	1,154.46
210701	Гадаад албан томилолт	-	-	-	-
210702	Дотоод албан томилолт	1,448,000.00	16,716,600.00	(15,268,600.00)	1,154.46
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	766,500.00	68,380,181.00	(67,613,681.00)	8,921.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	222,000.00	68,019,681.00	(67,797,681.00)	30,639.50
210806	Мэдээллийн технологийн зардал	544,500.00	360,500.00	184,000.00	66.21
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	13,023,900.00	52,557,866.00	(39,533,966.00)	403.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,023,900.00	52,557,866.00	(39,533,966.00)	403.55
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,287,000.00	3,900,000.00	6,387,000.00	37.91

Насан туршийн боловсролын үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2131	Засгийн газар хоорондын шилжүүлэг	-	-	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,287,000.00	3,900,000.00	6,387,000.00	37.91
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,387,000.00	-	6,387,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	3,900,000.00	3,900,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	191,420,400.00	283,891,827.00	(92,471,427.00)	148.31
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	143,820,400.00	137,303,149.00	6,517,251.00	95.47
131001	Улсын төсвөөс санхүүжих	143,820,400.00	137,303,149.00	6,517,251.00	95.47
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	47,600,000.00	310,060.00	47,289,940.00	0.65
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	47,600,000.00	310,060.00	47,289,940.00	0.65
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		146,278,618.00	(146,278,618.00)	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		146,278,618.00	(146,278,618.00)	-

